

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН  
АЛБАНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 07 дүгээр сарын 04-ний өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Үндэсний геологийн албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээ, үйл ажиллагаанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилтын хэрэгжилтийн явцад 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн хурсэн түвшнийг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлгэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны 2025 оны 06 дугаар сарын байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн тайландаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Үндэсний геологийн албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Ерөнхий чиг үүрэг 5, Үндсэн чиг үүрэг 5, зорилт 1-ийн хүрээнд 16, зорилт 2-ын хүрээнд 8-аас 1 арга хэмжээ хугацаа болоогүй, зорилт 3-ын хүрээнд 15-аас 1 арга хэмжээ хугацаа болоогүй, зорилт 4-ийн хүрээнд 9-өөс 4 арга хэмжээ хугацаа болоогүй, зорилт 5-ын хүрээнд 16 арга хэмжээ нийт 63 арга хэмжээнээс 7 арга хэмжээ хугацаа болоогүй, хугацаанд хэрэгжсэн 56 арга хэмжээ байна.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны  
2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга  
хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний товчоо**

Чиг үүрэг	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь					Хэрэгжилт /хувь/
		85-аас дээш	60-84%	30-59%	0-29%	х/б	
Нэг: Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, судалгаа шинжилгээ хийх	16	15	1	-	-	-	97.2
Хоёр: Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагийн судалгаа хийж эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.	9	5	3	-	-	1	90
Гурав: Үндэсний геологи, эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсэн сан, нэгдсэн сан бурдүүлэх, баяжуулах, сонирхсон	15	13	-	-	-	2	100

хэрэглэгчийг хуулиар хориглоогүй мэдээллээр хангах.							
Дөрөв: Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд бий болсон геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн мэдээлүүд болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл	9	5	-	-	-	4	100
Тав: Төрийн захиргааны болон хүний неөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад харилцааг өргөжүүлэх, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, эрсдлийн удирдалгаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах, байгууллагын санхүү, төсвийг удирдах, тайлагнах.	16	16	-	-	-	-	97.58
<b>Дүн</b>		-	-	-	-	-	<b>96.95</b>

### Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг **96.95** хувиар үнэлэв.

### Тав. Санал, зөвлөмж

- Зорилтыг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгоог тухай бүр цуглуулж тайланда хавсаргах;
- Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, тайлангийн чанар, утга найруулгыг хянах.

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА

Б.ӨНӨМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Г.БАТЧИМЭГ